

2023

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ТАНИЛЦУУЛГА



1919

ИХ БРИТАНИД
БАЙГУУЛАГДСАН



120

УЛС ОРОНД ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ



1994

МОНГОЛ УЛСАД ҮЙЛ
АЖИЛЛАГААГАА ЭХЛҮҮЛСЭН

Хүүхдийг Ивээх Сан бол 1919 онд байгуулагдсан, хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг бөгөөд шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага юм. Хүүхдийг Ивээх Сан нь нийгэм, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт, онцгой байдлын үеэс урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангахыг дэмжин ажиллаж ирсэн.

Бид хүүхдийг хамгаалж, эсэн мэнд амьдрах, хөгжих эрхийг хангахын төлөө тэмцэж, хүүхдийг өөрт байгаа боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглахад нь тусалдаг. Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийг сонсож, тэднийг оролцуулж, хүүхдийн амьдралд чухал нөлөө үзүүлэх аливаа шийдвэр гаргахдаа тэдний үзэл бодолд зохих ач холбогдол өгдөг хариуцлагатай нийгмийг цогцлоохын төлөө ажилладаг.

Хүүхдийг Ивээх Сан өнгөрсөн 100 гаруй жилийн хугацаанд өргөжин тэлж, өнөөдөр дэлхийн 120 гаруй улсад үйл ажиллагаа явуулж байна. 1994 онд нээгдсэн Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр 1994-2009 онд Их Британийн Хүүхдийг Ивээх Сангийн, 2009 оноос Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага дор хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох аргазүйг эрхэмлэн ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА:

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох



ЭРХЭМ ЗОРИЛГО:


Бодит дэвшил гаргах замаар хүүхдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах



ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД:

- Боловсрол
- Хүүхэд хамгаалал
- Хүүхдийн эрхийн засаглал
- Хүүхдийн ядуурлыг бууруулах
- Эрүүл мэнд
- Хүмүүнлэгийн яаралтай тусламж

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН МОНГОЛ УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ ОРОН НУТАГ



ДАРААХ ГУРВАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД БОДИТ ДЭВШИЛ ГАРГАХАД ЧИГЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА:



ЭСЭН МЭНД АМЬДРАХ

Урьдчилан сэргийлж болох шалтгаанаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг таслан зогсооно



СУРАХ

Бүх хүүхэд чанартай суурь боловсрол эзэмшиж чаддаг болсон байна



ХАМГААЛУУЛАХ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчдэг болсон байна

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм таны амгаланг эрэн мэндчилье.

Хүүхдийг Ивээх Сангийн хувьд улиран одсон жил бүр өөр өөрийн өнгө аястай, онцлогтой, үр дүнтэй байдаг билээ. Бид 2023 онд хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, залуусын оролцоотой хот байгуулалт, малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, хөдөө орон нутгийн эмнэлгүүдийн эмч, ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр төслүүд амжилттай хэрэгжүүлэн дуусгаж, эдгээрийн үр өгөөжийг олон зуун хүнд хүргэлээ. Түүнчлэн хүүхэд хамгаалалд сэтгэцийн гэмтэлд суурилсан даван туулагчдад ээлтэй үйлчилгээний арга зүйг нэвтрүүлэх, орон нутгийн өсвөр үеийн хүүхэд, залуучуудын бизнес үр чадвар, энтрепренершип боловсролыг дэмжих, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зэрэг төслийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн хэрэгжүүлэв.

Өнгөрсөн онд манай хамт олон “Зудад өртсөн малчид, малчдын хүүхдүүдэд туслах”, “Үерийн гамшигт өртсөн Баянзүрх дүүргийн гэр бүл, хүүхдүүдэд туслах” хүмүүнлэгийн хоёр томоохон төслийг амжилттай хэрэгжүүлж, олон зуун иргэн, хүүхдүүдэд яаралтай тусламж үзүүлж, эд материал болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэндээ баяртай байна.

Зудад өртсөн малчид, малчдын хүүхдүүдэд туслах төслөөр Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Төв аймгийн 22 сумын 1,230 малчин өрхөд малын тэжээл, бэлэн мөнгөний тусламж үзүүлснээр тэднийг байгаль цаг агаарын хүндрэлийг даван туулахад нь дорвитой дэмжлэг болсон юм. Түүнчлэн, уг төслөөр 1,772 малчдын хүүхдэд эрүүл ахуйн багц, 15 сумын дотуур байр тус бүрт 400 ширхэг зөөлөн эдлэл, боловсролын багц, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, анхны тусламжийн багц, зорилтот бүлгийн 300 хүүхдэд дулаан гутал өгсөн нь олон хүүхдэд өвлийг тохитой, дулаан давах боломж бүрдүүлсэн. Харин Улаанбаатар хотод болсон үерийн гамшигт өртсөн гэр бүл, хүүхдүүдэд туслах төслөөр 288 хүүхдэд сурагчийн дүрэмт хувцас, биеийн тамирын гутал, цүнх, хичээлийн хэрэгсэл, 278 хүүхдэд хоёр төрлийн мультивитамин, 25 айлд 5 ханатай иж бүрэн гэр, 250 өрхөд ахуйн халдваргүйтгэлийн бодис, 358 өрхөд хөнжил, эрүүл ахуйн шаардлага хангасан ус зөөвөрлөх, хадгалах сав өгсөн билээ. Энэ төсөл нийт 1,237 хүнд, үүнээс 403 нь хүүхдэд хүрч тэдэнд үерийн гамшигийг богино хугацаанд даван туулах, хүүхдүүдийн боловсролыг тасралтгүй явуулах боломж бүрдүүлсэн юм.

Хүүхдийг Ивээх Сангийн 2023 оны төсөл, хөтөлбөрүүдийн үр шимийг 265,000 гаруй хүүхэд, 39,000 гаруй насанд хүрэгчид хүртсэн байна.

Манай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэгч, хандивлагчдадаа болон эцэг эхчүүд, хүүхдүүд, Хүүхдийн Эрхийн тухай Конвенцын хэрэгжилтийг хангахад хамтран ажилласан бүх байгууллагууд болон тэдгээрийн удирдлага, ажилтнуудад талархал илэрхийлэхийн ялдамд та бүхний хүүхдийн төлөөх гэгээн үйлс үргэлж дэлгэрч байхыг ерөөе.

Хүүхдийг Ивээх Сангийн 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцана уу.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн менежер,
суурин төлөөлөгч Л.Баян-Алтай

2023

ОНД БИД

265,352

Хүүхдийг Ивээх Сан 2023 онд Монголын 265,352 хүүхдэд дэмжлэг үзүүллээ.



2 сая

2023 онд бид давхардсан тоогоор 2 сая гаруй хүнд шууд бусаар хүрч ажиллалаа.



304,556

2023 онд бид нийт 304,556 хүнд шууд хүрч ажиллалаа.

39,204

Насанд хүрсэн 39,204 хүн манай төсөл, хөтөлбөрүүдийн үр шимийг хүртжээ.



60

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бичиг үсгийн боловсролгүй 60 малчин эцэг эх уншиж, бичиж, тоолж сурлаа.

6,823

6,823 хүүхдийн анги дэвших, суралцах үйл явцад дэмжлэг үзүүлэв.



2023

ОНД БИД



1,289

1,289 албан хаагчдыг сэтгэцийн гэмтэлд суурилсан даван туулагчдад ээлтэй үйлчилгээний арга зүйн багц мэдлэгээр чадавхжуулав.

167

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвд хандивласан автомашин хоёр сарын хугацаанд нийт 167 түргэн тусламжийн дуудлаганд явсан байна.

13,087

Нийт 13,087 хүнд хүмүүнлэгийн тусламж хүргэлээ.

92,000

Биднийг цахим орчинд 92,000 хүн идэвхтэй дагажээ.



3,047,841

2023 оны төслийн нийт орлого 3,047,841 ам.доллар



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР

Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх стратегийн зорилгынхоо хүрээнд 2023 онд нийслэлд болон аймгуудад нийт 39 хамтарсан баг, 29 сургуульд суурилан төслүүд хэрэгжүүлэв. Үүнд:



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл (2021-2024) нь хүүхэд хамгаалалд ажилладаг 97 байгууллагын 1,289 мэргэжилтэн, алба хаагчдыг нийт 121 хоногийн турш 37 удаагийн сургалтаар дамжуулан сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх үр чадварт сургалаа. 12-18 насны охид, эцэг эх/асран хамгаалагчид, үйлчилгээ үзүүлэгч нарт чиглэсэн олон талт нөлөөллийн арга хэмжээг гурван үе шаттай хэрэгжүүлж, 40 зурагт хуудас, 47 видео, 5 телевизийн нэвтрүүлэг, 4 нийтлэл, 17 үйл ажиллагааны нийт 113 контент бүтээсний сацуу, “Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын мэдлэг, хандлага, дадал”-ын түвшинг тодорхойлж, “Хүүхэд хамгааллын мэдээллийн системийн үнэлгээ”-г хийлээ.



“Сургуультай хамтран Хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл (2023-2025) нь ЕБС-ийн багш ажилтнууд, эцэг эхчүүдийг хүүхдийн сурч, хөгжих үйл явцыг хүчирхийллийн бус аргаар дэмжих арга зүйгээр чадавхжуулах Модуль-1 сургалтаар 170 сургагч багшаар дамжуулан 700 багш ажилтанд хүргэв. Хүүхэд хамгаалалд сургууль ба хамтарсан багийн хамтын ажиллагааг сайжруулахад

чиглэсэн Модуль-2 сургалтаар 14 хамтарсан багийн 84 гишүүдийг чадавхжуулан ажилласан байна. Мөн 141 багш нарыг “Сайн эцэг, эх” хөтөлбөрийн сургагч багшаар бэлтгэн, 784 эцэг эх, асран хамгаалагчдыг сургалаа.



2023 онд “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” сургалтын тогтолцоог бэхжүүлэхэд анхаарахын зэрэгцээ сургалтын хөтөлбөр, арга зүйг Монгол Улсын Засгийн газарт шилжүүлэх үйл явцыг эхлүүлж, ГБХЗХГ “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн чиглүүлэгч бэлтгэх сургалтыг төвийн болон зүүн бүсийн 8 аймгийн нийт 32 мэргэжилтнийг сургав. Бид Канадын PDEL байгууллагатай хамтран ажиллан, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг хэрэгжүүлэх үндэсний сургагчид 5 хүнийг нэр дэвшүүлэн гэрчилгээжүүлэх үйл явцыг үргэлжлүүлж, 28 чиглүүлэгч бэлтгэлээ. Мөн эцэг эхчүүдэд зориулсан 15 хөтөлбөрт 216 эцэг эх, асран хамгаалагч хамрагдлаа.

“Чи ганцаараа биш” нөлөөллийн ажлын воркшопын үеэр сургагч охид



“ОХИДЫГ ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС ХАМГААЛАХ НЬ” ТӨСӨЛ

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Сан, НҮБ-ын Итгэлцлийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл (2021-2024) нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргийн 12-18 насны охидыг эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан жендэрт суурилсан хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлээс хамгаалах зорилготой.

Төсөл нь охидын эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд хүүхэд хамгааллын чиглэлээр салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажилладаг. Түүнчлэн, хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтэн, алба хаагчдыг чадавхжуулах сургалтаар дамжуулан сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх ур чадвартай болгох улмаар уг үйлчилгээний арга зүйг нэвтрүүлэх, тогтолцоог бий болгоход анхаарал хандуулж ажилладаг.

“Цахим орчин дахь охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл” сэдэвт хакатоны оролцогчид



© Н.Оюун/Хүүхдийг Ивээх Сан 2023

ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЦАХИМ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

Төслийн хүрээнд охидыг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан цахим нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулсан. Нөлөөллийн "Чи ганцаараа биш" аян 12-18 насны охидод чиглэсэн бол, "Бүү өнгөрөө: Хүүхэдтэйгээ ярилцаарай" сэдэвт хоёр дахь аян эцэг эх, асран хамгаалагчдад зориулагдав. "Нөлөөлье, Өөрчилье" сэдэвт 3 дахь нөлөөллийн ажил нь цахим орчин дахь хүүхэд хамгаалал, цахим орчны зохистой хэрэглээний талаарх мэдлэг мэдээллийг түгээх аян байлаа. Эдгээр аяныг нэг жил гаруй хугацаанд зохион байгуулж, нийт 113 контент (40 зурагт хуудас, 47 видео, 5 ТВ нэвтрүүлэг, 4 нийтлэл, 17 арга хэмжээ) бүтээв. 2023 оны 12 дугаар сарын байдлаар боловсруулагдсан контент нь цахим орчинд автагдсан тоогоор нийт 35,809,205 үзэлт, хандалт авсан байна.

40 
зурагт хуудас

47 
видео

5 
ТВ нэвтрүүлэг

4 
нийтлэл

17 
арга хэмжээ хийв



"Чи ганцаараа биш" нөлөөллийн
ажлын воркшопын үеэр сурагч охид



ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ

Төслийн Зорилт 1-ийн хүрээнд 11 модулийн агуулгаар үйлчилгээ үзүүлэгч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа. Нийт 1,289 мэргэжилтэн, алба хаагчдыг нийт 121 хоногийн сургалтад хамруулсан. Чадавхжуулах сургалтад хамрагдсан бүх оролцогчид сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх арга барилд суралцаж, ур чадвараа нэмэгдүүлсэн.

“ Нийт 1,289
мэргэжилтэн,
алба хаагчдыг
121 хоногийн
сургалтад
хамруулсан. ”



СУРГУУЛЬД СУУРИЛСАН ҮЕ ТЭНГИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төслийн зорилтот 15 сургууль дээр үе тэнгийн санаачилсан нөлөөллийн ажил зохион байгуулахад дэмжлэг үзүүлээ. 2023 онд сургууль тус бүр 3 нөлөөллийн ажил хийв. Үүнд:



Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын журмыг боловсруулж, багш, ажилтнууд, эцэг эхчүүдэд түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Уг үйл ажиллагаанд нийт 517 багш, 557 эцэг эх, 2,188 сурагчийг хамруулав.



Жил бүрийн 10-р сарын 11-ний өдөр тохиодог "Олон улсын охидын өдөр"-ийг тэмдэглэж, охидод тулгарч буй жендэрийн тэгш бус байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг нийт 11,511 сурагчдыг хамруулан зохион байгуулав.



Үе тэнгийнхний дээрэлхэл, цахим орчин дахь болон цахим орчноос үүдэлтэй бэлгийн дарамт, сарын тэмдгийн эрүүл ахуй, цахим дээрэлхэл зэрэг сэдвийн хүрээнд нөлөөллийн ажил зохион байгуулж, 260 гаруй багш, 300 эцэг эх, 3,530 сурагч хамрагдав.

“ Олон улсын охидын эрхийг
хамгаалах өдөр 11,511
сурагчдыг хамруулсан
нөлөөллийн ажил хийв ”





Гэр бүлийн марафоны оролцогчид



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН САЛБАРЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫН СУДАЛГАА

Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын эвслээс боловсруулсан аргачлал, загварыг ашиглан хүүхэд хамгааллын салбарын мэдлэг, хандлага, дадлын судалгааг хийв. Энэхүү судалгаа нь хүүхэд хамгааллын талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадлыг тодорхой болгох үндсэн зорилгын хүрээнд дараах гурван зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн:

- 1 Хүүхэд хүмүүжлийн талаарх насанд хүрэгчдийн хандлагыг тодорхойлох.
- 2 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох.
- 3 Хүүхэд хамгааллын талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох. Судалгааны мэдээллийг 18 ба түүнээс дээш насны 1,202 насанд хүрэгчдээс цуглуулсан.



МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ҮНЭЛГЭЭ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Монгол Улсад хүүхэд хамгааллын салбарт хэрэглэгдэж буй “НАМС”, “Эйбл”, “И-Тусламж”, “Хүүхдийн тусламжийн утасны 108” гэсэн дөрвөн үндсэн программд мэдээллийн системийн үнэлгээ хийв. Уг үнэлгээгээр дээрх дөрвөн программын хууль, эрх зүйн орчин, мэдээллийн систем, өгөгдөл, динамик тогтолцоонд иж бүрэн үнэлгээ хийж, программуудын үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн бодитой санал, зөвлөмж гаргах зорилготой байв.

Цагдаагийн ерөнхий газрын алба хаагчид хүүхэд хамгааллын чадавхжуулах сургалтад хамрагдаж, сертификатаа авсан нь



“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан 2023 оны 1-р сараас Хонконгийн Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилттэй “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлж эхэллээ. Төслийн хүрээнд сонгогдсон орон нутаг, ерөнхий боловсролын сургуулиуд, хамтарсан багууд, сургуулийн ажилтнууд, эцэг эхчүүдийг хүүхдийн сурч, хөгжих үйл явцыг хүчирхийллийн бус аргаар дэмжихэд чиглүүлэх юм. Мөн сургууль болон хамтарсан багийн хамтын ажиллагааг сайжруулан бэхжүүлэх, улмаар эцэг эх, асран хамгаалагчдыг хүүхэд хамгааллын асуудалд анхаарч, идэвхтэй оролцдог практикийг бий

болгох юм. Түүнчлэн хүүхдийн оролцоог дэмжих замаар тэдэнд тулгардаг болзошгүй бэрхшээлийг даван туулах, үе тэнгийнхэндээ зөвлөн туслах үр чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагаануудыг төслийн хүрээнд хэрэгжүүлж байна. Төслийн үр дүнд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх чиглэлд орон нутгийн оролцогч талуудын чадавх бэхэжсэн байх юм.

“Төсөл нь 2023-2025 онд Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг болон Говь-Алтай, Ховд аймгийн 14 сургууль, 14 хамтарсан багийг хамруулан хэрэгжиж байна.”



ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



Сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллыг сайжруулахад сургуулийн багш, ажилтнуудын мэдлэг, ур чадвар, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор Модуль 1 ба 2 сургалтын багцыг боловсруулан гаргаж, багш нарын төлөөллөөс сургагч багш нарыг бэлтгэн, бусад багш, ажилтнуудыг сургалтад хамрууллаа. Ингэснээр тэдний хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах мэдлэг, дадал сайжирч байна.



Хүүхэд хамгаалалд сургууль болон Хамтарсан багийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор төслийн зорилтот Хамтарсан багийн гишүүдийг Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр чадавхжуулах сургалтад хамрууллаа. Үр дүнд нь Хамтарсан багийн гишүүд нь Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхдээ сургуультай хамтран ажиллах арга зүйтэй болж байна.



Хүүхдээ хүчирхийллээс ангид хүмүүжлийн эерэг аргаар өсгөн хүмүүжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн аргачлалаар боловсруулагдсан “Сайн эцэг, эх” сургалтын модулийг боловсруулан, сургагч багш нарыг бэлтгэн, эцэг эх, асран хамгаалагчдыг сургалтад хамрууллаа.



Өсвөр үеийнхэнд чиглэсэн “Би найзаа дэмжинэ” олон улсын сургалтын хөтөлбөр, арга зүйг монгол хэлнээ боловсруулан түгээн дэлгэрүүлэхэд бэлэн боллоо.

Төслийн мониторингийн үйл ажиллагаа, Ховд аймагт

Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн Биологийн багш О.Мядагмаа сурагчидтай ангийн дүрмийн талаар ярилцаж байна.

“Төсөлд хамрагдаад, сургалтад сууж, олон зүйлийг сурч мэдсэн. Тухайлбал, хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг аль болох эрт илрүүлэх шаардлагатай юм байна. Илрүүлсэн тохиолдолд ямар хариу арга хэмжээ авах гэх мэтийн арга зүй, ур чадварт суралцсан. Багш хүн сурагчдаа ажиглах, харилцан ярилцах нь хүртэл эрт илрүүлэгт чухал юм билээ. Багш хүн өөрөө энэ бүхнийг мэдээд авахаар санаатай болон санамсаргүй байдлаар ч хүүхэдтэй зүй зохисгүй харьцахгүй зан төлөвт суралцаж байна.”

Говь-Алтай аймгийн Дарив сумын
Ерөнхий боловсролын сургуулийн
Нийгэм, иргэний ёс зүйн боловсролын
багш Б.Бүтэнжаргал

“Сургуультай хамтран Хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хэрэгжилтийн явцын хяналт үнэлгээг хийхээр Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд Говь-Алтай аймгаас Ховд аймаг явах замд. Зураг дээр зүүн гар талаас хяналт-шинжилгээ, үнэлгээний зохицуулагч Б.Бүрэнтөгс, жолооч Д.Батсүх, Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтан Э.Оюунмаа



“ӨДӨР ТУТАМ ХЭРЭГЛЭХ ХҮМҮҮЖЛИЙН ЭЭРЭГ АРГА” ДЭД ХӨТӨЛБӨР

“Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” дэд хөтөлбөр нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийтээрээ үл тэвчих мэдлэг, хандлага, дадлыг бий болгох Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн зорилт, Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улсад хэрэгжүүлэх Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн стратегийн хүрээнд хэрэгжиж байна. Эцэг эх, асран хамгаалагчид, багш нарын хүүхдийг хүчирхийллийн бус, эерэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг, хандлага, зан үйлд нөлөөлөх эерэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх замаар хүүхдийн эсрэг бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг бүх орчинд халахад хувь нэмэр оруулах үндсэн зорилготой.



“Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн чиглүүлэгч бэлтгэх сургалтын оролцогчид бүлгийн ажлын үеэр

“ӨДӨР ТУТАМ ХЭРЭГЛЭХ ХҮМҮҮЖЛИЙН ЭЕРЭГ АРГА” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ГОЛ ҮР ДҮН:



“Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” сургалтын тогтолцоог бэхжүүлэхэд анхаарахын зэрэгцээ сургалтын хөтөлбөр, арга зүйг Монгол Улсын Засгийн газарт шилжүүлэх үйл явцыг эхлүүллээ. “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн сургалтын тогтолцоог бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд төрийн байгууллага буюу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай 2022-2027 онд хамтран ажиллахаар Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. ГБХЗХГ “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн чиглүүлэгч бэлтгэх сургалтыг төвийн болон зүүн бүсийн 8 аймгийн нийт 32 мэргэжилтнийг сургалаа.



“Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн үндэсний сургагчид 5 хүнийг нэр дэвшүүлэн гэрчилгээжүүлэх үйл явцыг Канадын PDEL байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Хүүхдийг Ивээх Сан “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийг эцэг эхчүүдэд зохион байгуулах 28 чиглүүлэгчийг бэлтгэлээ.



Канадын “Positive Discipline in Everyday Life” төрийн бус байгууллагатай хамтран эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг хэрэгжүүлэх чиглүүлэгч бэлтгэх сургалтыг 2023 оны нэгдүгээр сар, наймдугаар саруудад нийт 2 удаа зохион байгууллаа. Энэ хугацаанд эцэг эхчүүдэд зориулсан 15 хөтөлбөрт 216 эцэг эх, асран хамгаалагч хамрагдлаа.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” хөтөлбөрийн оролцогчид



“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛОД ХҮРТЭЭМЖТЭЙ, ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХЭД ЗАЛУУСЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан “Улаанбаатар хотын гэр хороололд хүртээмжтэй, таатай орчин бүрдүүлэхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх” төслийг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр 2022 оны 6 дугаар сараас 2023 оны 5 дугаар сарыг дуустал хэрэгжүүллээ.

Энэ төсөл гэр хорооллын орчныг сайжруулахад залуучуудын утга учиртай оролцоог хангах зорилготой байв. Сонгинохайрхан дүүргийн 7 хороо,

Сүхбаатар дүүргийн 2 хороо, Чингэлтэй дүүргийн 2 хороонд амьдарч буй залуусыг хот байгуулалт, хөгжүүлэлтийн ажлуудад оролцоог нэмэгдүүлэх энэхүү төсөл Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд түшиглэн хэрэгжсэн юм. Уг төсөл нь залуусын нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, хот байгуулалтад залуусын оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг дэмжих зэрэг чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаа явуулсан байна.

“Залуусын хэрэгцээнд тулгуурлан боловсруулсан “Залуу элч” хөтөлбөрт нийт 150 гаруй хүмүүс оролцож, цуврал сургалтуудад хамрагдаж, бичил төслүүдийг санаачлан хэрэгжүүлсэн юм.”



ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



ЗАЛУУСЫГ ХОТ БАЙГУУЛАЛТАД ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛУУДЫГ ГҮЙЦЭТГЭВ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 7 хороо, Чингэлтэй болон Сүхбаатар дүүргийн нийт 4 хороонд амьдрах залуусыг орон нутгийн хөгжил, хот байгуулалтад оролцоог нэмэгдүүлэх “Залуу элч” хөтөлбөр явагдаж, нийт 150 гаруй залуус хамрагдлаа. Уг хөтөлбөрөөр дамжуулан залуус хот байгуулалтын зарчмууд, зөөлөн үр чадвар, судалгааны талаарх мэдлэгээ ахиулж, сурсан зүйлсээ хөтөлбөрт хамрагдсан хорооны бусад залууст сургалт хийв.



ЗАЛУУСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААГ ТЭДНИЙ ОРОЛЦООТОЙ ГҮЙЦЭТГЭВ

Улаанбаатар хотын Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төв орчмын 600 гаруй залуусын нөхцөл байдлын талаарх ойлголтыг сайжруулах судалгааны ажлыг “Залуу элч” хөтөлбөрт оролцсон залуусын оролцоотой гүйцэтгэлээ. Уг судалгаа нь залуусын ядуурлын нийгмийн үзүүлэлт, жендэрийн үзүүлэлт, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал болон тэдний иргэний оролцоог хамруулан судаллаа.



Залуус бичил төслүүдээ амжилттай хэрэгжүүлэв. Хөтөлбөрт хамрагдсан залуус 6 багт хуваагдан сургалтад хамрагдаж, бичил төслийн санал боловсруулан, буцалтгүй олгогдох санхүүжилт авч амжилттай хэрэгжүүллээ. Тэдний хэрэгжүүлсэн төслүүдийг дурдвал “Гэр хорооллын хаягжилтыг сайжруулах нь”, “Мэдлэгтэй өрөө”, “Хүүхэд хөгжлийн төвийг залуусын оролцоотой тохижуулах нь”, “3х3 сагсан бөмбөгийн талбай”, “Аюулгүйн толь”, “Ногоон Сэлбэ” зэрэг санаачилгыг олон оролцогч тал, үр шим хүртэгч нарыг хамруулж хэрэгжүүлж чадлаа.





“Миний хувьд “Залуу манлайлагч” хөтөлбөрийн дараа “Би оролцох ёстой, оролцоотой байх ёстой” гэдгээ ойлгосон. Өмнө нь өөрт тулгарсан гудамж, хорооны асуудлуудаа ойр дотны хүмүүстэйгээ л ярилцдаг байлаа. Сургалтын дараа нийгмийн идэвхтэй, хариуцлагатай байх ёстой, хороо, дүүргийнхэнтэйгээ хамтарч ажиллах ёстой гэсэн бодол надад хүчтэй төрсөн. Залуу манлайлагчид энэхүү төслөө дуусгасан ч цаашид бусдад тодорхой хэмжээгээр нөлөөлөхийг эрмэлзээд явж байгаа.”

Э.Лханаасүрэн, Сонгинохайрхан дүүргийн 9-р хорооны оршин суугч, “Залуу манлайлагч” хөтөлбөрийн оролцогч



“Улаанбаатар хотын гэр хороололд хүртээмжтэй, таатай орчин бүрдүүлэхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх” төслийн Залуу манлайлагч нар



БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

Бид 2023 онд хүүхэд болон насанд хүрэгчдийн суралцахуйг дэмжих, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын орчныг сайжруулах, тэгш хамруулах боловсрол, үл ялгаварлах хандлага ойлголтыг түгээх чиглэлээр хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүлээ. Үүнд:



Монгол Улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийг Боловсрол, шинжлэх ухааны яам хэрэгжүүлж, Хүүхдийг Ивээх Сан төслийн санхүүжилтийг зохицуулагч байгууллагаар ажиллаж байна. Уг төслийн удирдах хороо 2023 оны хэрэгжилтийг 86 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийнхээ сурч хөгжих болон сайн сайхан байдлыг дэмжих чадавхыг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлж дууслаа. Уг төслийн хүрээнд Өвөрхангай, Ховд аймгийн зорилтот сумдад 60 малчин өрх, Насан туршийн боловсролын төвийн 16 багш, мэргэжилтнүүд хамрагдаж төслийн үр шимийг хүртсэн байна.



Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийг үе тэнгийн хүүхдүүдийн оролцоонд тулгуурлан дэмжих зорилготой АХБ-ны санхүүжилттэй “Хамтдаа суралцъя” бичил төслийг боловсруулж, нийслэл болон 3 аймгийн 8 сургууль, цэцэрлэгт амжилттай хэрэгжүүлээ. Зорилтот сургууль, цэцэрлэгийн 20 багш, 92 сурагчийг хүүхдийн манлайлал, нөлөөллийн ажил зохион байгуулах арга зүйн сургалтад хамруулж, 2,744 хүүхдийг хамруулсан сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулав.



Японы Гадаад хэргийн яамны санхүүжилттэй “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь -2” төслөөс тэгш хамруулах боловсролын сургалтын модуль, гарын авлагуудыг шинэчлэн боловсруулж, шат дараалсан сургалтуудыг зохион байгууллаа. Эдгээр сургалтад зорилтот 16 дунд сургуулийн нийт 932 багш хамрагдаж, тэгш хамруулах боловсролын сургалтын арга зүй, тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжих хөтөлбөрийн арга зүйд суралцлаа.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэлгийн хүчирхийллээс өөрийгөө хамгаалах аргад суралцахад нь дэмжлэг үзүүлэх, тэдэнд учирч болзошгүй бэлгийн хүчирхийллийн эрсдэл, үр дагавраас сэргийлэх зорилготой “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах, аюулгүй байдлаа хангах чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийг Шинэ Зеланд Улсын элчин сайдын яамны санхүүжилтээр Ерөнхий боловсролын 3 дунд сургууль, 3 НТБТ-д хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд хүүхдүүд болон насанд хүрэгчдэд зориулсан хоёр гарын авлага боловсруулж, холбогдох сургалтууд зохион байгууллаа.





“Зорилтот сургуулиудын нийт 1,624 эцэг эхчүүд сургалтад хамрагдаж, хүүхдийнхээ сурах үйл явцыг дэмжих арга зүй, оролцоо, нөлөөллийн арга барилд суралцлаа.”

“ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ-2” ТӨСӨЛ

Японы Гадаад хэргийн яамны санхүүжилттэй “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслөөс тэгш хамруулах боловсролын сургалтын 3 модуль, 1 гарын авлагыг шинэчлэн боловсруулж, сургагч багшийн болон сургуулийн сургалтуудыг зохион байгууллаа. Эдгээр сургалтад зорилтот 16 дунд сургуулийн нийт 932 багш хамрагдаж тэгш хамруулах боловсролын сургалтын арга зүй, тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжих хөтөлбөрийн арга зүйд суралцлаа. Мөн зорилтот сургуулиудын нийт 1,624 эцэг эхчүүд сургалтад хамрагдаж, хүүхдийнхээ сурах үйл явцыг дэмжих арга зүй, оролцоо, нөлөөллийн арга барилд суралцлаа.

Төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх зорилгоор дараах арга хэмжээг зохион байгууллаа.

- Улаанбаатар, Ховд, Өвөрхангай аймгийн төслийн зорилтот бүс 32 ерөнхий боловсролын сургуулиудад тэгш хамруулах сургалтын хөтөлбөр, арга зүй, сайн туршлагын талаарх сургалтууд зохион байгуулж, мэдээллээ түгээлээ.
- ЕБС-ийн багш нарт зориулсан сургалтын 6 модуль гарын авлагыг бие даан суралцах e-module хэлбэрт шилжүүлэн Боловсролын ерөнхий газрын багшийн хөгжлийн портал сайтад байршуулав.
- Аймаг, нийслэлийн Боловсрол, Шинжлэх ухааны газар, Боловсролын хэлтсийн тэгш хамруулах боловсрол хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан төслийн үр дүн, туршлагыг хуваалцах үндэсний семинарыг 2023 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгууллаа.

ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



Төслийн үр дүнг үнэлэх, бий болсон туршлага, сургамж дээр үндэслэн санал зөвлөмжийг боловсруулах зорилгоор төслийн эцсийн үнэлгээний арга зүйг боловсруулах, оролцогч талуудаас мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх, тайлангийн төслийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Тусгай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, тэдний сурах, хөгжих эрхийг хангах зорилгоор тэгш хамруулах боловсролын бодлогын форум, уулзалтуудыг оролцогч талуудтай тогтмол зохион байгуулж ажиллалаа. Үүний үр дүнд Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуульд “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын талаарх бие даасан бүлэг заалтыг оруулж 2023 онд баталгаажууллаа. УИХ-аар баталгаажсан энэхүү Боловсролын хуулийн шинэчлэлтээр сургууль, цэцэрлэгүүд суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчныг бүрдүүлэх, тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж байгаа багш, ажилтанд нэмэгдэл хөлс олгох зэрэг олон үүрэг хүлээж байна.



“Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуульд “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын талаарх бие даасан бүлэг заалтыг оруулж 2023 онд баталгаажууллаа.”



Төслийн хэрэгжилтийн 2 дахь жилд ЕБС-ийн бага, дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсролын онол, арга зүйн мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх, хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн арга зүй эзэмшүүлэх, мөн эцэг эх, олон нийтэд тэгш хамруулах боловсролын талаарх эерэг ойлголт өгч, хандлагад нь нөлөөлөх зорилго бүхий сургалтын модулиудыг шинэчлэн боловсруулж хэвлүүлэн, холбогдох сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:



193



Тэгш хамруулах боловсрол- “5 дугаар ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтын модулийн сургалтад зорилтот сургуулийн 193 бага ангийн багш, шилжилтийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, боловсролын тусгай хэрэгцээтэй болон сурлагын хоцрогдолтой 185 сурагчийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжин ажиллажээ.

295



Тэгш хамруулах боловсрол- “Хамтдаа дэвшин суралцъя” сургалтын гарын авлагын сургалтыг нийт 295 сурагчдын зөвлөлийн гишүүдийг хамруулан зохион байгууллаа. Эдгээр хүүхдүүд зорилтот сургуулийнхаа 3,600 сурагчид, үе тэнгийнхнийг оролцуулсан сургалт, тэгш хамруулах боловсролыг дэмжих нөлөөллийн ажлуудыг сургууль дээрээ зохион байгуулжээ.

739



Тэгш хамруулах боловсрол- “ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль”-ийн сургалтад зорилтот сургуулийн дунд ангийн 739 багш хамрагдлаа.

922



Тэгш хамруулах боловсрол- “Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модулийн сургалтад 922 багш хамрагдлаа. Мөн Улаанбаатар хот Өвөрхангай, Ховд аймгийн зорилтот сургуулиуд болон Насан түршийн боловсролын төвүүдийн нийт 1,624 эцэг эхчүүд сургалтад хамрагдаж, хүүхдийнхээ сурах үйл явцыг дэмжих арга зүй, оролцоо, нөлөөллийн арга барилд суралцлаа.

- Тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан сургуулийн дэд бүтцийг сайжруулах засварын ажлыг Ховд, Улаанбаатар хотын төслийн зорилтот 7 сургуульд хийж, тэдгээр хүүхдүүдийн хэрэгцээнд нийцсэн ариун цэврийн өрөө, налуу зам зэргийг ашиглалтад орууллаа.
- Япон улсын Тэгш хамруулах боловсролын тогтолцоотой танилцаж, туршлага судлах зорилготой суралцах аялыг төслийн зорилтот сургууль, орон нутгийн боловсролын хэлтэс, БШУЯ, БЕГ-ын төлөөллийг оролцуулан 2023 оны 9 дүгээр сард амжилттай зохион байгууллаа. Сургалтад оролцогчид Токио болон Осака мужийн Ерөнхий боловсролын сургуулиуд, орон нутгийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа, хүүхдийн хувийн онцлогт нийцүүлэн чанартай сургах багш нарын арга барилтай танилцаж, хүн тус бүр өөр өөрийн байгууллагад нэвтрүүлэх сайн туршлагатай боллоо.
- Улаанбаатар хотын зорилтот 12 сургуулийн багш, сургалтын менежер, захирлуудын төлөөллүүд Ховд, Өвөрхангай аймагт очиж зорилтот сургуулиудын туршлагаас судалж, харилцан мэдээлэл солилцсон нь үр дүнтэй болж, сургуулиудын идэвх, санаачилга нэмэгдсэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.
- Хүүхдийн оюун ухааны хөгжлийг тодорхойлох Монгол-Танака Бине сорил авагч бэлтгэх сургалтыг МУБИС-тай хамтран зохион байгуулснаар төслийн бүх 16 сургууль сорил авагчтай боллоо. Төслийн нийт хугацаанд 60 гаруй хүнийг сорил авагчаар бэлтгэсэн байна.
- Тэгш хамруулах боловсролын талаарх олон нийтийн ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилготой “Хамтдаа суралцъя” сошиал болон хэвлэл мэдээллийн аяныг зохион байгууллаа. Энэхүү аяны хүрээнд 4 видео бүтээл, 7 постер, 7 амжилтын түүх, 19 нийтлэл, ярилцлагыг бэлтгэж зохих хэвлэл, мэдээлэл, сошиал орчинд нийтлүүлж олон нийтэд түгээсэн байна. Энэхүү нөлөөллийн аян 3,2 сая хүнд хүрч хандалт авчээ.
- “Тэгш хамруулах боловсрол” олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран, илүү өргөн хүрээнд олон нийтийг хамруулан зохион байгуулж, 300 гаруй багш, эцэг эх, сурагчид өөрсдийн сонирхсон чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас үнэ төлбөргүй мэдээлэл, зөвлөгөө авч, тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах, харилцах талаар мэдлэг ойлголтоо бэхжүүллээ.





Ховд аймгийн төслийн зорилтот сургуулийн нэг болох Ерөнхий боловсролын 7 дугаар сургуульд 2011-2023 онд суралцаж төгссөн Б.Жавзан охин хөгжлийн бэрхшээлтэй хэдий ч сургуульдаа амжилттай суралцаж, элсэлтийн ерөнхий шалгалтаа Монгол хэл, Нийгмийн ухааны хичээлээр өгч, өөрийн эзэмшихийг хүссэн Сэтгэл судлалын мэргэжлээр МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуульд 1 дүгээр курст суралцаж байна. Б.Жавзан элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхдээ төслийн зүгээс зорилтот сургууль бүрт тохижуулж өгсөн “Хүүхэд хөгжлийн танхим”-д хичээллэн, Монгол хэл, Нийгмийн ухааны хичээлийн багш нартайгаа ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу суралцжээ.

Б.Жавзан:

“Элсэлтийн шалгалтаа өгсний дараа сандраад 1 хоног оноогоо харж чадаагүй, оноо гарснаас 1 хоногийн дараа өөрийнхөө сурахыг хүссэн сургуулийн босго оноог хангалттай дээгүүр давсан гэдгээ хараад маш их баярласан. Намайг шалгалтад бэлтгэсэн багш нартаа, ангийнхандаа маш их баярладаг. Их сургуульдаа ороход манай 7 дугаар сургуулийн захирал, сургалтын менежер, ангийн багш, шалгалтад бэлтгэсэн багш нар маань ирж манай ангийнхантай уулзаж, надад амжилт хүсэхэд нь их сайхан санагдсан. Би сэтгэл судлалын ангиа төгсөөд, хөгжлийн ялгаатай, түүндээ сэтгэл дундуур байдаг хүүхдүүдэд туслахыг хүсэж байна. Би их сургуулиа амжилттай төгсөж, надтай адилхан дүү нартаа суралцах итгэл, урам зориг өгмөөр байна.”



“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь -2” төслийн ажилтан Г. Уянга Өвөрхангай аймгийн Уянга сумын 1 дүгээр сургууль дээр ажиглалт хийж буй нь

“ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ” ТӨСӨЛ

Төслийн гурван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ. Үүнд:



Тэгш хамран сургах боловсрол бүрэлдэхүүний хүрээнд 18 зорилтот сургуулиудад "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим" байгуулж, нийт 802 сая төгрөгийн санхүүжилтээр мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, тавилга, ном сурах бичиг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих тоног төхөрөмж, туслах хэрэглэгдэхүүнийг нийлүүлэв. Мөн зорилтот 4 аймаг, 2 дүүргийн нийт 160 ерөнхий боловсролын сургуулийн 678 удирдлагын багийн гишүүд болон 2,334 бага ангийн багш нарт "Тэгш

хамран сургах боловсролын онол, ганцаарчилсан төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ"-ний чиглэлээр 3 өдрийн сургалт амжилттай зохион байгууллаа. Сургалтын үр дүнд сургууль, багш ялгаатай хэрэгцээт хүүхдийг ойлгох, боловсролын үйлчилгээнд хамруулах талаар эерэг ойлголт хандлагатай болж, багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцсан. Тэгш хамруулах боловсролд эцэг эхийн оролцоог хангах, үе тэнгийн хүүхдүүдийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн жижиг төслийг зорилтот 18 сургууль дээр хэрэгжүүллээ. Сургууль тус бүр дээрх чиглэлээр тус бүр нэг жижиг төслийг боловсруулан хэрэгжүүлж нийт 86 сая төгрөгийн санхүүжилт авав.



Сургуулийн үдийн хоол бүрэлдэхүүний хүрээнд нийслэл болон орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн "Хоол зүйч"-ийг хөрвүүлэх сургалтаар бэлтгэж байна. Одоогийн байдлаар 14 оюутан хөрвүүлэх сургалтыг



амжилттай төгсөж ЕБС-д хоол зүйчээр ажиллаж байна. Хоёр өдрийн чадавх бэхжүүлэх сургалтыг зорилтот 45 сургуулийн 150 гаруй нийгмийн ажилтан, удирдлага, хоол зүйч, тогооч нарт зориулан 2023 оны 10-р сард зохион байгуулав. Дотуур байрны сурагчдад зориулсан “Шим тэжээл ба эрүүл мэнд” хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлууллаа. “Сургуулийн хүүхдийн үдийн хоол” үндэсний чуулга уулзалтыг БШУЯ, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран зохион байгуулж 1,200 гаруй төлөөлөгч оролцож сургуулийн үдийн хоолны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэв.



Хосолсон сургалт бүрэлдэхүүний хүрээнд хосолсон сургалтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний компанийг сонгон шалгаруулж, хосолсон сургалтын 4 загварыг зорилтот 50 сургуульд туршин хэрэгжүүлэхэд бэлэн боллоо. Туршилтын үр дүнд тулгуурлан хосолсон сургалтын дэд бүтцийн стандарт боловсруулах, хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын тогтолцоог сайжруулах хүний нөөцийг чадавхжуулах ажлыг хийх юм.

ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИП БОЛОВСРОЛ ОЛГОХ ТӨСӨЛ

Япон Улсын “Нийгмийн хөгжлийн сан”-гийн санхүүжилт, Дэлхийн банкны менежменттэй хэрэгжиж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл” (2019-2025) нь өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох замаар сурлагын амжилтыг сайжруулж, цаашлаад хөдөлмөр эрхлэлтэд бэлдэх зорилготой.

Төсөл нь Монгол Улсын баруун, зүүн, төвийн болон хангайн бүсийн төлөөлөл болох Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн ядуурлын төвшин өндөртэй, алслагдсан 25 сумын 14-25 насны 8,000 өсвөр насны хүүхэд, залуучуудад сургууль болон хөдөлмөрийн зах зээлд өндрөөр үнэлэгддэг хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэх сургуульд суурилсан, орон нутгийн залуучууд өсвөр үеийнхний оролцоотой “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байна. Түүнчлэн хөтөлбөрөөс сурсан мэдлэгээ бодитоор турших боломж олгон, өсвөр үеийнхний боловсруулсан бичил төслийг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлэх, тэдний туршлагыг харилцан хуваалцах боломж олгох үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг.

“Төсөл нь 2023 оны эцэст 1.5 жилээр сунгагдаж, дээрх зорилтуудын цар хүрээг нэмэгдүүлэхээр үргэлжилж байна.”



ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



2023 онд зорилтот 5 аймгийн 29 сумын 2,780 хүүхэд, залуус хоёр удаагийн “Энтерпренерт суурилсан хувь хүний үр чадварыг хөгжүүлэх сургалт”-ын (ESEL) хөтөлбөрт хамрагдан, өөртөө итгэх итгэл, хувь хүний онцлогийг таних, цагийн менежмент, багаар ажиллах, ялгаатай хэрэгцээг таних, санхүүгийн нөөцийг хуваарилах, ашиглах, эрсдэлийг урьдчилан харах, бизнесийн төсөл боловсруулах зэрэг үр чадварт суралцлаа. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш уг хөтөлбөрт нийт 7,970 хүүхэд, залуус хамрагдаад байна.



ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдаж, амжилттай төгссөн хүүхэд, залуучууд хамтдаа баг болон орон нутагтаа хэрэгжүүлэх бизнес санаануудаа боловсруулж, Pitch арга хэмжээний үеэр танилцуулан, шалгарсан төслүүд нь санхүүгийн дэмжлэг авч, сургалтаар олж авсан мэдлэг, үр чадвараа улам хөгжүүлж байна. 2023 оны эцсээр нийт 1,185 хүүхэд, залуус 290 бичил төслийн санхүүжилт авснаар бизнес санаагаа бодитоор хэрэгжүүлэх боломжтой болсон.



Бичил төсөл хэрэгжүүлж буй суралцагчдын туршлага солилцох Үндэсний уулзалт

© Т.Гантуулгалыг/Хүүхдийг Ивээх Сан 2023



© Е.Нямдаваа/Хүүхдийг Ивээх Сан 2023



Түүнчлэн энтерпренершип боловсрол, үйл ажиллагааг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, сургуулийн менежментийн хөгжлийг дэмжих зорилгоор төслийн зорилтот 5 аймгийн 6 суманд сургуульд суурилсан энтерпрайз (ССЭ) санаачилгыг хэрэгжүүлж байна. Эдгээр ССЭ төслүүд нь сурагчид болон сумын иргэдийг эрүүл хүнсний ногоогоор хангах, өглөөний цайны соёлыг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, сургуулийн сурагчид болон сумын иргэд, албан байгууллагуудад дутагдаж буй цахим үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах, дуу бичлэг, цахим хөгжлийн үйлчилгээгээр хангах, технологийн хичээлээр дамжуулан өсвөр үеийнхэнд энтерпренер боловсрол олгон бизнесийн үйл ажиллагаатай практикт суурилсан сургуулийг бий болгохоор тус тус хэрэгжиж байна.



Завхан аймгийн Баянтэс сумын ЕБС-ийн 11-р ангийн сурагч Б.Санжааханд, Б.Эрдэнэзуу, Н.Болормаа нар нь төслийн ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдан “Entrepreneur seeds” бичил төслийн уралдаанд “Эко хүнс” төслөөрөө оролцож, 3,455,000 төгрөгийн буцалтгүй санхүүжилт авчээ. Энэхүү “Эко хүнс” төслийг нь эрс тэс уур амьсгалтай Баянтэс суманд дутагдалтай байдаг өргөн хэрэглээний хүнсний ногооны хэрэгцээг хангах зорилгоор санаачилсан байна.



“Бид сургуулиа төгстлөө хүлэмжийн ногооныхоо бизнесийг үргэлжлүүлж, дараа ангийн дүү нартаа өвлүүлэх зорилготой. Өөрөө тариад ургуулсан ногоогоо амсах үе бол ялсан, асуудлаа шийдсэн, чадсан амттай мэдрэмж байсан. Ийм мэдрэмж л хүнд урагшлах эрч хүч өгдөг юм байна. Манай багийнхан төслөө хэрэгжүүлэхдээ зөвхөн ашиг олохдоо бус харин сурагч насандаа үр бүтээлтэй, хариуцлагатай, аливаа зүйлд тэмүүлэн зорьж, түүнийгээ хамтдаа бүтээвэл амжилтад хүрч болох тухай амьдралын хамгийн том хичээлийг олж авч чадсан.”

“Эко хүнс” төслийг санаачилсан сурагчдын нэг
Н.Болормаа



Завхан аймгийн Тэлмэн сумын
“Өв уламжлалаа дээдэлж цахим
орчноос татгалзъя” бичил
төслийн үйл ажиллагаатай
танилцаж сур харвааны анхны
байрлал заалгаж буй Хүүхдийг
Ивээх Сангийн Завхан аймаг
дахь салбарын зохицуулагч
П.Дөлгөөн

ХҮҮХДИЙН ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР

Хүүхдийг Ивээх Сан, “Хөгжлийн шийдэл” ТББ, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газартай хамтран Global Youth Entrepreneurship Challenge (GYEC) буюу Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдааныг долоо дахь жилдээ зохион байгууллаа. Англи, Монгол хэлээр явагдсан уг тэмцээний эхний шатны шалгаруулалтад Улаанбаатар хот болон орон нутгийн 22 сургуулийн 48 багийн 272 сурагч оролцсоноос сүүлийн шатанд 16 багийн 100 гаруй сурагч шалгарсан юм. “Ирээдүйн амьдралын хэв маягийг харуулсан бүтээгдэхүүн” сэдвийн дагуу 12 цагийн дотор бизнес санаагаа боловсруулж, түүнийхээ дагуу бүтээгдэхүүний загвар гаргаж, бизнес төлөвлөгөөгөө танилцуулж өрсөлдөв. Сурагчид харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан мэдрэгч камер, хүний кинетик энергийг ашиглан хөдлөх үед халдаг хүрэм, хэрэгцээт газарт агаараар эм, эмийн бүтээгдэхүүн хүргэж өгөх зэрэг олон сонирхолтой бизнесийн шийдэл, загвар бүтээгдэхүүн боловсруулж, шүүгчдэд танилцуулан питч хийсэн юм.

Тэмцээний тэргүүн байранд Орчлон сургуулийн GerLink баг өдөр тутмын хувцаслалтыг хялбаршуулах хиймэл оюун ухаанд суурилсан AR технологийн санаа дэвшүүлж тэргүүлсэн. Удаах байранд 44-р сургуулийн Bud Power баг хүний кинетик энергийг ашиглан хөдлөх үед халдаг хүрэм хийх санаагаар, харин 3 дугаар байранд орсон найзуудын Neves баг орон нутаг болон бусад хэрэгцээт газарт агаараар эм, эмийн бүтээгдэхүүн хүргэж өгөх үйлчилгээний төслөөр тус тус шалгарлаа.



“Тэмцээний эхний гурван байр эзэлсэн багууд Япон Улсын “Center for Entrepreneurship Development” байгууллагаас зохион байгуулдаг өсвөр үеийнхний бүтээлч сэтгэлгээг шинжлэх ухаантай уялдуулан хөгжүүлэх зорилго бүхий Олон Улсын Өсвөрийн Энтрепренерүүдийн Уралдаанд эх орноо төлөөлөн оролцсон юм.”

Хүүхдийг Ивээх Сан, “Хөгжлийн шийдэл” ТББ, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдааны үеэр

ДЕНАН ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан АНУ-д төвтэй “Денан төсөл”-ийн санхүүжилтээр Эрүүл мэндийн төслийг Архангай аймгийн Эрдэнэмандал суманд 2017 оноос, Тариат суманд 2012 оноос, Говь-Алтай аймгийн Чандмань суманд 2022 оноос тус тус хэрэгжүүлж байна.



ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



167 ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГАД ЯВАВ

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд зориулан шинэ авто машин хандивлалаа. Энэхүү автомашины худалдан авалтыг Говь-Алтай аймгийн Чандмань сумын Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөл хамтран санхүүжүүлэв. Автомашиныг 2023 оны 11 дүгээр сарын 1-нд хүлээлгэн өгснөөс хойш 2 сарын хугацаанд нийт 167 түргэн тусламжийн дуудлагад явсан бөгөөд үүнээс алсын дуудлага нь 60 байжээ.



138 ХҮҮХЭД ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧ БАГШ БОЛОВ

Говь-Алтай аймгийн 8 сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн клубын нийт 138 гишүүн хүүхдүүдийг "Үе тэнгийн сургагч багш" хөтөлбөрийн онол, дадлага хосолсон сургалтад хамрууллаа. Мөн тус аймгийн Чандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн клубын үйл ажиллагаанд зориулан тоног төхөөрөмж хандивлав.



1,167 ХҮНД ШҮДНИЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭВ

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Эрүүл мэндийн төвд 2022 оны 11 сард орчин үеийн иж бүрэн амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх боломжтой кабинетыг байгуулсан билээ. Тус кабинет нь үйл ажиллагаа явуулж эхэлснээр Говь-Алтай аймгийн Чандмань сумын бүх насны иргэд төдийгүй ойролцоох 4 сум, Баянхонгор аймгийн 2 сумдын нийт 1,167 хүнд амны хөндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.



18 ХҮНИЙ ЦЭЭЖНИЙ РЕНТГЕН ЗУРАГ АВАВ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвд 2022 оны 10 дугаар сард зөөврийн дижитал рентген аппарат хүлээлгэж өгсөн юм. 2023 онд гэмтэлтэй, томуу болон КОВИД-19-ын халдварын хүндрэлтэй нийт 18 хүний рентген зургийг авсан байна.



1,599 ХҮҮХДИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРУУЛАВ

Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бугат, Дарив, Жаргалан, Төгрөг, Тонхил, Хөхморьт, Шарга, Чандмань зэрэг 9 сумын 1,599 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулж, мөн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулсан байна. Түүнчлэн тухайн орон нутгийн шүдний өвчлөлийн тархалтын судалгааг явуулж, статистик боловсруулалтыг хийж байна.



“Манай эмнэлгийн түргэн тусламжийн автомашин 2021 оноос ашиглах боломжгүй болж, эмнэлгийн тусламж үйлчилгээг тасалдахгүй хүргэхэд бэрхшээл тулгарсан. Энэ автомашин цаг үеэ олсон чухал хөрөнгө оруулалт болж байна. Ирсэн өдрөөсөө тусламж үйлчилгээнд явж эхэллээ.”

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Бат-Эрдэнэ



Save the Children

**“ДЕНАН ТӨСӨЛ”-ИЙН
САНХҮҮЖИЛТЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨСӨЛ**

**THE HEALTH PROJECT
FUNDED BY “THE DENAN
PROJECT”**

“СУМДЫН ЭМНЭЛЭГТ ХҮҮХДИЙН ГЭМТЛИЙН ҮЕИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ, БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”

2023 онд Австралийн Элчин Сайдын Яамны санхүүжилттэй, ГССҮТ-ийн мэргэшсэн сургагч багштай хамтран алслагдсан бүс нутаг болох Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Алтай сумд, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумдад эрүүл мэндийн тусламж үзүүлж буй эмч, эмнэлгийн ажилтнууд, хүүхэдтэй ажилладаг төрийн албан хаагчдад чиглэсэн “Сумдын эмнэлэгт хүүхдийн гэмтлийн үеийн яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах, бэхжүүлэх төсөл”-ийг амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд гэмтлийн үед яаралтай тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулж, мөн эмнэлгийн бэлэн байдлыг хангах тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.



“Сумдын эмнэлэгт хүүхдийн гэмтлийн үеийн яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах, бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн Алтай суманд зохион байгуулсан сургалтын үеэр

ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



3 суманд гэмтлийн яаралтай тусламжийн иж бүрдэл хандивлав
Зорилтот сумдын эрүүл мэндийн төвүүдэд гэмтэлтэй өвчтөнийг тээвэрлэхэд
нэн шаардлагатай бүх төрлийн бэхэлгээ, хөдөлгөөн хязгаарлагч, яаралтай
тусламжийн багц, бэлэн байдлын цүнх, эмнэлгийн тоног төхөөрөмжийг
хүлээлгэн өгөв.



39 эмч, эмнэлгийн ажилтнуудыг ажлын байран дээр чадавхжуулав
Дээрх 3 сумдын эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж буй 7 их эмч, 11
сувилагч, 9 эх баригч, 12 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан гэмтлийн
үеийн яаралтай тусламж, тэр дундаа хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн
сургалтыг ажлын байранд нь зохион байгуулж, багаар нь хамрууллаа.



115 иргэн анхны тусламжийн чадавхжуулах сургалтад хамрагдав
Зорилтот сумдын багш, төрийн албан хаагчид, малчид, ахлах ангийн
сурагчид зэрэг нийт 115 иргэн осол, гэмтлийн үеийн анхны тусламжийн
сургалтад хамрагдаж чадавхажлаа.

“ Хүүхдийн гэмтлийн үеийн яаралтай тусламжийг газар дээр нь хэрхэн цаг алдалгүй
үзүүлэх талаар онолын болон гардан үйлдэл, дадлага хосолсон сургалтыг сумын эрүүл
мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад явууллаа. Ингэснээр осол, гэмтэлд
өртсөн хүүхдүүдийг гэмтлийн улмаас тахир, дутуу болох эрсдэлийг бууруулж, хоёрдогч
гэмтлээс хэрхэн сэргийлэх талаар мэдлэгтэй болгосноороо ач холбогдолтой. ”

Сурагч багш, ГССҮТ-ийн эмч Б.Батсайхан





Хүүхдийг Ивээх Сангийн
Эрүүл мэндийн төслийн
ажилтан Б.Номин сумын
иргэдэд “Сумдын эмнэлэгт
хүүхдийн гэмтлийн үеийн
яаралтай тусламжийн
чадавхыг сайжруулах,
бэхжүүлэх төсөл”-ийн
сургалт явуулж байгаа нь

ХҮМҮҮНЛЭГИЙН ХӨТӨЛБӨР

Хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөр нь гамшиг, хямралд өртсөн эмзэг бүлгийн хүүхэд, гэр бүл, малчдад хүмүүнлэгийн тусламжийг цаг алдалгүй хүргэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байх, эрсдэлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг. Хүүхдийг Ивээх Сан 2023 онд Хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрийн хүрээнд 2 төсөл амжилттай хэрэгжүүлэв.



ЗУДАД ӨРТСӨН МАЛЧИД, МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАХ ТӨСӨЛ

Хүүхдийг Ивээх Сан өвөлжилт хүндэрсэн Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Төв аймгийн малчид болон малчдын хүүхдүүдэд туслах хүмүүнлэгийн төслийг Их Британийн Старт сан, Олон улсын Хүүхдийг Ивээх Сангийн “SEED” хүмүүнлэгийн сан, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлэв.



ҮЕРИЙН ГАМШИГТ ӨРТСӨН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАХ ТӨСӨЛ

Үерийн гамшигт өртсөн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 21, 27, 29-р хорооны гэр бүл, хүүхдүүдэд туслах төслийг Олон улсын Хүүхдийг Ивээх Сангийн “SEED” хүмүүнлэгийн сан, Солонгос болон Японы Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэв.

ҮЕРИЙН ГАМШИГТ ӨРТСӨН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАХ ТӨСӨЛ

Улаанбаатар хотод 2023 оны 8 дугаар сарын 5-ны өдөр хүчтэй аадар бороо орж, Баянзүрх дүүргийн 21, 27, 29-р хорооны олон айл өрх үерт өртсөн юм. Хүүхдийг Ивээх Сан үерийн гамшигт өртсөн гэр бүл, хүүхдүүдэд туслах төсөл хэрэгжүүлж, олон төрлийн тусламж хүргэлээ. Хүүхдийг Ивээх Сангийн Хүмүүнлэгийн сан, БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сан болон Японы Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр хэрэгжсэн энэ төсөл нийт 1,237 хүнд, үүнээс 403 нь хүүхдэд хүрсэн байна.



ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:

ҮЕРИЙН ГАМШИГТ НЭРВЭГДСЭН ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАМЖ ХҮРГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Нийт 288 хүүхдэд сурагчийн дүрэмт хувцас, биеийн тамирын гутал, цүнх, хичээлийн хэрэгсэл, 278 хүүхдэд хоёр төрлийн мультивитамин, 108 өрхөд 10 хүртэлх насны хүүхдийн хөнжил, гудас, даавуу, дэр бүхий багц хүлээлгэн өгөв.



Үерийн гамшигт хүндээр өртсөн өрхүүдэд тусламж хүргэх үйл ажиллагаа. Хүнд байдалд нэрвэгдсэн 25 айлд 5 ханатай иж бүрэн гэр, 250 өрхөд ахуйн халдваргүйтгэлийн бодис, 125 өрхөд хөнжил, 125 өрхөд ус зөөвөрлөх зориулалтын 50 литрийн сав зэргээр тусламж хүргэв.



“Хүүхдэд үзүүлэх сэтгэлзүйн анхны тусламж” сургалтыг насанд хүрэгсэд болон хүүхдүүдэд хүргэлээ. Баянзүрх дүүргийн 48, 102, 127 дугаар сургуулийн багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, тус дүүргийн 21, 27, 29 дүгээр хороодын хөгжлийн нийгмийн ажилтан, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчид, Баянзүрх дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсролын хэлтэс, Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд нийт 35 хүн хамрагдав. Үерийн улмаас гэр бүл нь хохирол амссан, сэтгэлийн зовуурь, түгшүүртэй нийт 298 хүүхдийг хамрууллаа.

“ Машиныуд эргэлдэж, мөргөлдөөд байсан. Манай хашааны хаалгыг машин мөргөөд, тэгээд ус ороод ирсэн. Надад бол уурламаар санагдсан. Миний хувцаснууд шавхайтай, муухай болчихсон байна лээ. Зарим урагдаагүйг нь угаагаад аваад ирсэн. Манай гэрийн дээвэр дээр цахилгаан буусан. Айлуудын хашаа нь эвдрээд, зарим айлын Монгол гэр нь урсаад явчихсан. Би уг нь зуны даалгавраа хийчихсэн байсан. Даанч үерт урсаад явчихсан. Гэхдээ манай ангийн багш үерт урссан гэдгийг мэдэж байгаа.”

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 24 дүгээр сургуулийн сурагч Г.Санжаадагва



Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд
хамгааллын төслийн ажилтан
П.Цэдэндамба “Үерийн гамшигт
өртсөн Баянзүрх дүүргийн гэр
бүл, хүүхдүүдэд туслах” төслийн
хүрээнд хүүхдүүдэд цүнх,
хичээлийн хэрэгсэл, дүрэмт
хувцас тараах үеэр



“Үерийн гамшигт өртсөн Баянзүрх дүүргийн гэр бүл, хүүхдүүдэд туслах” төслийн хүрээнд хүүхдүүдэд цүнх, хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцас тараах үеэр Хүүхдийг Ивээх Сангийн захиргаа, худалдан авалтын ажилтан Ч.Гэрлээ



2022-2023 оны өвөл Монгол орны ихэнх нутагт цас их орон хүйтэрч 70 гаруй хувьд нь зуд болж, олон мянган мал хорогдсон байна. Хүүхдийг Ивээх Сан хүмүүнлэгийн яаралтай тусламжийн хөтөлбөрийг Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Төв аймгийн 22 суманд хэрэгжүүлэв. Энэхүү хөтөлбөр нь зудад өртсөн орон нутгийн малчдын хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах зорилготой байлаа.



ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:



Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Төв аймгийн 22 сумын зудад өртсөн 1,230 малчин өрхөд малын тэжээл, бэлэн мөнгөний тусламж үзүүлэв. Хүмүүнлэгийн тусламжийг хонин толгойд шилжүүлснээр 300 болон түүнээс цөөн тооны малтай, зудын эрсдэлд өртсөн, олон хүүхэдтэй, өрх толгойлсон, ахмад насны иргэнтэй малчин өрхүүдэд хүргэсэн юм.



Эдгээр 5 аймгийн 22 сумын дотуур байранд амьдарч байгаа 1,772 сурагчид эрүүл ахуйн багц өгөв.



Завхан, Говь-Алтай аймгийн 6 сумын Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээнд зориулан мөнгөн тусламж үзүүлэв.



Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Төв аймгийн 15 сумын дотуур байр тус бүрт 400 ширхэг зөөлөн эдлэл (хөнжил, гудас, цагаан хэрэгсэл зэрэг зүйлс), боловсролын багц (ном, тоглоом зэрэг зүйлс), хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, анхны тусламжийн багц өгөв.



Эдгээр 5 аймгийн 15 сумын олон ам бүлтэй айлын хүүхдүүд, өнчин, хагас өнчин, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой зорилтот бүлгийн 300 хүүхдэд дулаан гутал өглөө.



ХҮМҮҮНЛЭГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ



Хүүхдийг Ивээх Сангийн санхүүгийн ажилтан А.Соёл-Эрдэнэ, Захиргаа, Хүний нөөцийн менежер Х.Дэлгэрзаяа нар 2023 оны 3 дугаар сард Баянхонгор аймгийн зудад өртсөн малчин өрхүүдэд тусламж хүргэж байгаа нь.



“ Хайртай ишиг Халзкагаа зуданд алдсан. Хашаандаа үхсэн хэвтэж байхыг нь харах муухай байсан. Өвөл цас их ороод цасан шуурга болоход би дургүй. Их цас ороход аав ээждээ санаа зовдог, бас малдаа санаа зовдог. Нар хурдан гараасай гэж боддог. ”

Т.Бямба-Очир, Завхан аймгийн
Баянтэс сум
2023 оны 3 дугаар сар

Хүүхдийг Ивээх Сангийн худалдан авалтын ажилтан Г.Ариунжаргал Завхан аймгийн Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын хүүхдүүдэд эрүүл ахуйн багц түгээж байгаа нь.



2023 ОНД ХЭВЛЭГДСЭН НОМ, БҮТЭЭЛ



Хүүхдийг Ивээх Сангийн танилцуулга



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 1



Тэгш хамруулах боловсрол-“ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль”



Тэгш хамруулах боловсрол-“Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модуль



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 2



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 3



Хамтдаа дэвшин суралцъя гарын авлага



Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй



Хүүхдийг Ивээх Сангийн улирал тутмын цахим сонин дугаар 4



Тэгш хамруулах боловсрол- “5 дугаар ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтын модуль



“Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллаж буй сайн туршлага” ном



“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн мэдээллийн хуудас #5



“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн мэдээллийн хуудас #6



“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн мэдээллийн хуудас #7



“Бид бүгд ялгаагүй Cool” брошур



“Боловсролд тэгш хамруулах үзэл санаа, хэрэгжүүлэх менежментийн асуудлууд” ном



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах, аюулгүй байдлаа хангах чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийн танилцуулга



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэлгийн хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх арга зүйн зөвлөмж”
Эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага



“Анхаарлын дутмагшил ба хэт хөдөлгөөнтөх эмгэг гэж юу вэ?” багш нарт хүргэх зөвлөгөө



“Тусгай хэрэгцээт хүүхдээ хэрхэн дэмжих вэ?” эцэг эхчүүдэд хүргэх зөвлөгөө



“Би өөрийгөө хамгаална”
Хүүхдүүдийг хүчирхийллийн хохирогч болохоос сэргийлэх арга зүйн гарын авлага



“Би өөрийгөө хамгаална”
Хүүхдүүдийг хүчирхийллийн хохирогч болохоос сэргийлэх арга зүйн зөвлөмж



Тэгш хамруулах соёлыг түгээх, хандлага ойлголтыг өөрчлөх зорилготой “Хамтдаа” нөлөөллийн аяны цуврал постерүүд



“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн танилцуулга



“Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого” гарын авлага



“Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал” гарын авлага




“Жендэрт суурилсан хүчирхийлэл ба хүн худалдаалах гэмт хэрэг ба илрүүлэлт” гарын авлага



“Хүүхэд хамгааллын үйлчилгээ ба кейс менежмент” гарын авлага



“Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байрны үйлчилгээ” гарын авлага



“Хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах гэмт хэрэг ба илрүүлэлт” гарын авлага



“Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ” гарын авлага



“Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ” гарын авлага



“Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох нь” гарын авлага



“Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах нь” гарын авлага



“Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагсдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ” гарын авлага



“Бүтээлч тархи” охидын дэвтэр



“Мэдлэг, хандлага, дадлын асуулгын судалгааг хүүхэд хамгааллын салбарт хэрэглэх нь” МХД-ын асуулгын судалгааг хүүхэд хамгааллын салбарт хэрэглэх алхамчилсан зөвлөмж



“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих нь” төслийн “Тэгш хамруулах боловсрол” судалгааны тайлан



“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих нь” төслийн ердийн болон тухайн хэрэгцээт хүүхдүүдийн хоол тэжээлийн байдал суурь судалгааны тайлан



“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн суурь судалгааны тайлан



“Хүүхдэд зориулсан сэтгэлзүйн анхны тусламж” мэдээллийн хуудас



“Сумдын эмнэлэгт хүүхдийн гэмтлийн үеийн яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах, бэхжүүлэх нь” төслийн хүрээнд дахин хэвлэсэн “Яаралтай тусламжийн товч зааврууд”



“Эрүүл мэнд эрхэм баялаг” амжилтын түүхүүд



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хийсэн “Чи ганцаараа биш – Бүү нуугаарай, бүү нуугдаарай” өсвөр насны охидод зориулсан нөлөөллийн аяны цуврал постерүүд



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хийсэн “Чи ганцаараа биш – Бүү өнгөрөө, хүүхэдтэйгээ ярилцаарай!” эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан нөлөөллийн аяны цуврал постерүүд



Тэгш хамруулах соёлыг түгээх, хандлага ойлголтыг өөрчлөх зорилготой “Хамтдаа-2023” нөлөөллийн аяны видео бүтээлүүд



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийнхээ сурч хөгжих болон сайн сайхан байдлыг дэмжих чадавхыг сайжруулах нь” төслийн үр дүнгийн видео цуврал



Өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох төслийн 26 цуврал амжилтын түүх



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хийсэн “Чи ганцаараа биш – Бүү өнгөрөө, хүүхэдтэйгээ ярилцаарай!” эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан аяны видео бүтээлүүд



“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хийсэн “Чи ганцаараа биш – Бүү нуугаарай, бүү нуугдаарай” өсвөр насны охидод зориулсан аяны видео бүтээлүүд



“Зудад өртсөн малчид, малчдын хүүхдүүдэд үзүүлэх хүмүүнлэгийн яаралтай тусламж – 2023” төслийн хүрээнд хийгдсэн видео бүтээлүүд



“Үерийн гамшигт өртсөн Баянзүрх дүүргийн гэр бүл, хүүхдүүдэд туслах” төслийн хүрээнд хийгдсэн видео бүтээлүүд



“Улаанбаатар хотын гэр хороололд хүртээмжтэй, таатай орчин бүрдүүлэхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх” төслийн видео бүтээлүүд



Денан төслийн үр дүнгийн видео

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

782,374 Японы Нийгмийн Хөгжлийн Сан/Дэлхийн банк

329,345 Хүүхдийг Ивээх Сан (Япон)

53,041 Бусад

21,145 Австралийн Элчин Сайдын Яам

25,191 Денан Төсөл (АНУ)

47,799 GPE (Боловсролын төлөө дэлхийн түншлэл) сан

50,000 Хүүхдийг Ивээх Сан (Солонгос)

52,138 Азийн Хөгжлийн Банк



89,849 Швейцарийн Хөгжлийн Агентлаг

120,636 СТАРТ сан

139,684 Хүүхдийг Ивээх Сангийн ОУ-ын эвсэл

300,681 Хүүхдийг Ивээх Сан (Гонконг)

435,245 НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Сан

600,712 Япон Улсын Гадаад хэргийн яам

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Ам доллараар)	2023	2022
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	605,658.95	678,878.42
Авлага	309,885.40	319,095.97
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	966.09	604.85
Нийт эргэлтийн хөрөнгө	916,510.44	998,579.24
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	226,393.31	172,680.44
Нийт эргэлтийн бус хөрөнгө	226,393.31	172,680.44
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,142,903.75	1,171,259.68
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ		
Өр төлбөр		
Дансны болон бусад өглөг	11,509.90	8,026.37
Цалингийн өглөг	-	682.31
Татвар, шимтгэлийн өглөг	219.01	10,960.22
Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,728.91	19,668.90
Урт хугацаат өр төлбөр		
Нөөц ба өр төлбөр	283,211.28	221,535.74
Хойшлуулсан орлого	226,393.31	172,680.44
Урт хугацаат өр төлбөрийн дүн	509,604.59	394,216.18
Нийт өр төлбөрийн дүн	521,333.50	413,885.08

Цэвэр хөрөнгө		
Хязгаарлалттай нөөц	155,385.92	397,385.37
Үндсэн хөрөнгийн сан	78,421.90	105,221.45
Хуримтлагдсан үр дүн	387,762.43	254,767.78
Цэвэр хөрөнгийн дүн	621,570.25	757,374.60
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН	1,142,903.75	1,171,259.68

ОРЛОГО БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

(Ам доллараар)	2023	2022
Орлого:		
Төсөл хөтөлбөрийн орлого	3,047,840.69	2,556,891.29
Хандив, тусламжийн орлого	5,976.38	-
Бусад орлого	41,253.66	22,193.70
Нийт орлогын дүн	3,095,070.73	2,579,084.99
Зардал:		
Төсөл хөтөлбөрийн зардал	2,786,022.97	2,312,382.54
Ерөнхий удирдлагын зардал	271,502.93	244,622.71
Нийт зардлын дүн	3,057,525.90	2,557,005.25
Үйл ажиллагааны үр дүн	37,544.83	22,079.74
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	4,726.03	19,607.31
Валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	90,723.79	(69,695.99)
Тайлант жилийн үр дүн	132,994.65	(28,008.94)

ХАМТРАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

- Азийн Хөгжлийн Банк
 - Австралийн Элчин Сайдын Яам
 - Боловсролын Дэлхийн Түншлэл
 - Денан Төсөл
 - Дэлхийн Банк
 - Их Британийн Старт Сан
- НҮБ-ын Итгэлцлийн сан
 - Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл
 - Хүүхдийг Ивээх Сан, Солонгос
 - Хүүхдийг Ивээх Сан, Хонг Конг
 - Швейцарын Хөгжлийн Агентлаг
- Япон Улсын Гадаад харилцааны яам
 - Японы Нийгмийн хөгжлийн сан
 - Шинэ Зеланд Улсын Элчин сайдын яамны Сан

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

- Яам, агентлаг, харьяа байгууллага**

 - Боловсрол, шинжлэх ухааны яам
 - Боловсролын ерөнхий газар
 - Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
 - Боловсролын Үнэлгээний Төв
 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
 - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төв
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
 - Хууль зүйн хүрээлэн
 - Цагдаагийн Ерөнхий Газар
 - Гадаадын иргэн харьяатын газар
 - Эрүүл мэндийн яам
- Соёлын яам
 - Хүүхдийн 108 тусламжийн утас
 - Онцгой байдлын ерөнхий газар

Их, дээд сургууль

 - АШУҮИС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
 - Монгол Улсын Боловсролын Их Сургууль
 - ШУТИС-ийн Нийгмийн ухааны тэнхим
 - Ховд Хөгжил Политехник коллеж

Нийслэлийн Засаг даргын тамгын газар ба түүний агентлаг, харьяа байгууллагууд

 - Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар
 - Нийслэлийн боловсролын газар
 - Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
 - Нийслэлийн эрүүл мэндийн газар
- Нийслэлийн Цагдаагийн удирдах газар
 - Нийслэлийн Онцгой байдлын газар
 - Нийслэлийн бизнес, инновац, хөгжлийн газар
 - Нийслэлийн 9, 15, 150 дугаар цэцэрлэг

Аймгуудын Засаг даргын Тамгын газар ба харьяа байгууллага

 - Аймгийн Засаг даргын Тамгын газар
 - Архангай, Баянхонгор, Төв, Говьсүмбэр, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд
 - Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
 - Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Говь-Алтай
 - Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

- Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Говь-Алтай
- Аймгийн Насан туршийн боловсролын төв
 - Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд
- Аймгийн Онцгой Байдлын газар
 - Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Төв, Завхан
- Архангай, Говь-Алтай, Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар

Дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллага, хороо

- Баянзүрх дүүргийн 2, 12, 19, 21, 23, 27, 26, 29 дугаар хороо
- Баянгол дүүргийн 8, 16, 18, 20, 28 дугаар хороо
- Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Багахангай, Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэс
- Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс
- Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв
- Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 11, 21, 22, 27, 28, 33, 40 дүгээр хороо
- Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн боловсролын хэлтэс

- Сүхбаатар дүүргийн 9, 11, 13, 14, 16, 18, 19 дугаар хороо
- Чингэлтэй дүүргийн 7, 11, 12, 13, 14, 17, 18, 19 дугаар хороо

Сумдын Засаг даргын Тамгын газрууд

- Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын тамгын газар
- Говь-Алтай аймгийн Чандмань, Жаргалант, Бугат, Тонхил сумдын Засаг даргын тамгын газар
- Говьсүмбэр аймгийн Чойр, Шивээ-Овоо сумын Засаг даргын тамгын газар
- Завхан аймгийн Баянтэс, Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн, Тэс, Түдэвтэй сум
- Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Хархорин, Сант, Уянга, Хужирт сумын Засаг Даргын Тамгын Газар
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сумын Засаг даргын тамгын газар
- Ховд аймгийн Чандмань, Булган, Алтай, Манхан, Мөст, Үенч, Дарви сумын Засаг даргын тамгын газар
- Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Өлзийт сумын Засаг даргын тамгын газар
- Төв аймгийн Архуст, Эрдэнэ, Эрдэнэсант, Борнуур сумын Засаг даргын тамгын газар

Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв

- Баянзүрх дүүргийн Насан туршийн боловсролын төв, ерөнхий боловсролын 30, 33, 40, 48, 79, 85, 127, 148 дугаар сургууль, “Хангай” цогцолбор сургууль, “Ертөнц” дунд сургууль, “Амгалан цогцолбор” дунд сургууль
- Баянгол дүүргийн Насан туршийн боловсролын төв, ерөнхий боловсролын 13, 19, 40, 51, 73 дугаар сургууль
- Говьсүмбэр аймгийн Чойр, Шивээ-Овоо сумдын ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв
- Завхан аймгийн Баянтэс, Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн, Тэс, Түдэвтэй сумдын ЕБС, Насан туршийн боловсролын төв
- Өвөрхангай аймгийн Арвайхээр, Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Хархорин, Сант, Уянга, Хужирт сумдын ЕБС, Насан туршийн боловсролын төв
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сумдын ЕБС, Насан туршийн боловсролын төв
- Сонгинохайрхан дүүргийн Насан туршийн боловсролын төв, ерөнхий боловсролын 9, 67, 65, 76, 107, 121 дугаар сургууль
- Ховд аймгийн Жаргалант сумын 1, 3, 7 ЕБС, Булган, Алтай,

Манхан, Мөст, Үенч, Дарви сумдын ЕБС, Насан түршийн боловсролын төв

- Чингэлтэй дүүргийн Насан түршийн боловсролын төв, ерөнхий боловсролын 17, 24, 37, 39, 49, 50, 57, 61, 117 дүгээр сургууль,
- Сүхбаатар дүүргийн Насан түршийн боловсролын төв, ерөнхий боловсролын 2, 3, 16, 31, 58 дүгээр сургууль
- Хан-Уул дүүргийн Насан түршийн боловсролын төв, ерөнхий боловсролын 130, 75 дүгээр сургууль
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4-р сургууль, Дарив сум ЕБС

Политехник коллеж/Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв

- Ховд, Өвөрхангай, Завхан, Говьсүмбэр аймгийн Политехник коллеж
- Сүхбаатар аймаг, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв

Эмнэлэг

- Архангай аймгийн Тариат, Эрдэнэмандал сумын эрүүл мэндийн төв
- Говь-Алтай аймгийн Чандмань сумын эрүүл мэндийн төв

Олон улсын байгууллага

- Азийн Сан
- Дэлхийн Зөн Монгол
- НҮБ-ын Хүүхдийн сан

- Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

Төрийн бус байгууллага

- “Бүтээлч Тархи” Сэтгэл судлалын хүрээлэн ТББ
- Бодлого Судлалын Төв
- “Гүнж” төв ТББ
- “Иргэний Нээлттэй Цонх” НҮТББ
- Монголын Аутизмын холбоо
- Монголын Бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ
- Монголын Дауны холбоо
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
- “Монгол Өрх” Сэтгэл зүйн хүрээлэн ТББ
- Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо
- Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэг
- Мөрөөдөл” олон улсын төрийн бус байгууллага
- Сонсголгүйн боловсрол ТББ
- “Фаро Сан” ТББ
- Хөгжлийн шийдэл ТББ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо
- “Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв” ТББ
- ШУТИС-ийн дэргэдэх “Нээлтэй нийгэм” төв

Хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, маркетингийн байгууллагууд

- Вайрал-Партнерс ХХК
- Грийн инсайт судалгааны байгууллага ХХК

- Ди ди Принт ХХК
- Дижитал Индастри
- Зөгий.мн сайт
- Ийгл Бродкастинг ХХК
- Импресс Колоур ХХК
- МАКС Хотелс ХХК
- МАКС лоджинг ХХК
- МҮОНРТ
- “Орлоо-Инфо” ХХК
- “Нэмүүн Бат” ХХК
- ХАСАБЭ Интернэшнл ХХК
- ЭМЭМСиЖи судалгааны байгууллага
- Хэвлэлийн хүрээлэн
- ЭМЭМСиЖи ХХК
- Эрэн контент ХХК
- С1 телевиз
- UBS телевиз

Хамтарсан баг

- Говь-Алтай аймгийн Дарив сум, Есөнбулаг сумын Баянхайрхан баг
- Ховд аймгийн Дарви сум, Жаргалант сумын Жаргалан баг
- Хан-Уул дүүргийн 2, 15 дугаар хороод
- Баянгол дүүргийн 2, 3 дугаар хороод
- Чингэлтэй дүүргийн 6, 13 дугаар хороод
- Сүхбаатар дүүргийн 7, 15 дугаар хороод
- Баянзүрх дүүргийн 1, 3 дугаар хороод



Save the Children

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361



www.savethechildren.mn



[Save the Children in Mongolia](#)



[Savethechildren.mongolia](#)



[Save the Children MN](#)



[Save the Children in Mongolia](#)